



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/202

Бат-Өлзий сум

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Статистикийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өвөрхангай аймгийн Засаг даргын “Аян зохион байгуулах тухай” 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/614 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн үнэн бодит байдлыг хангах ажлын хүрээнд сум, багийн хүн ам, өрхийн үзүүлэлтийн талаарх судалгааг бусад төрийн байгууллагуудтай хамтран шинэчлэх “Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн чанарыг сайжруулах” 2 сарын аяныг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Батлагдсан төлөвлөгөөний дагуу аяныг үр дүнтэй зохион байгуулж, тайлан төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Э.Дашдулам)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Н.ОРХОНТУУЛ